



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 01 өдөр


Дугаар 1/96

Амардалай

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.3, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2, Засгийн газрын 2021 оны "Босго үнэ шинэчлэн батлах тухай" 124 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2023 оны Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар "Эрүүл мэндийн төвд ус цэвэршүүлэх тоног төхөөрөмж суурилуулж, холбох" ажлыг 10.000.000 (Арван сая) төгрөгөөр хийж гүйцэтгэх үнийн санал ирүүлсэн "Аргил сувд" ХХК-д гэрээ байгуулах эрх олгосугай.
2. Гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, санхүүгийн холбогдох баримтыг бүрдүүлж ажиллахыг сангууд хариуцсан нягтлан бодогч (Г.Дэжидсүрэн)- д даалгасугай.

ДАРГА  М.БАЯРСҮХ